

ШАШИН, ӨВ СОЁЛ СУДЛАЛ - XIII

УРИАНХАЙН ТҮҮХ, ШАШИН, ӨР СОЁЛ

ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ



Улаанбаатар хот
2023



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
ФИЛОСОФИЙН ХҮРЭЭЛЭН



Шашин, өв соёл судлал-ХІІІ

УРИАНХАЙН ТҮҮХ, ШАШИН, ӨВ СОЁЛ

(ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ)

УЛААНБААТАР
2023

1847	АУ Зүүн амба- ны х.	сул амбан Дармаазар, Халхын жа- саанд суух засгийн тамгыг хамаарсан туслагч тайж Ду- гаржав	Дармаазарын эх Дулмаа зэрэг арван долоон хүн лам Жанцан зэрэг лам хар зургаан хүн	Дулмаа зэрэг арван долоон хүн, Хонгорелөн- гийн өртөө- ний цэрэг лам Жанцан зэрэг лам хар зургаан хүн	ТГ 27.10.7. (1847.11. 14.)	ТГ 27.10.10. (1847.11. 27.)	3-205-4898-28
1893	Захчин гүний хошуу	гүн Цэрэн- дорж	гүн Цэрэндорж, дагах түшмэл, ор- лон хөөгч Дэгжих гурван хүн	3 хүн	БД 18.11.25. (1893.1.12)	БД 18.12.20. (1893.2.6.)	國立故宮博物院典藏 > 統一編號: 故機172789 文獻編號: 603000085

Ном зүй

Архивын баримт

1. БНХАУ-ын Түүхийн Нэгдүгээр Архив 中国第一历史档案馆, Цэргийн Тухай Газар (Junjichu 軍機處), *lufu zouzhe* 錄副奏
2. Монгол Улсын Үндэсний Төв Архив, М-1, Хүрээнд сууж хэрэг шийтгэгч манж сайдын яам
3. Монгол Улсын Үндэсний Төв Архив, М-87 Жавзандамба хутагтын дотоод сан
4. Taiwan, National Palace Museum Collections 國立故宮博物院典藏 > Чин үеийн түүхийн данс эвхмэл 清代歷朝檔案文獻 (цахим архив: <https://qingarchives.npm.edu.tw/index.php?act=Archive>)

Ном зохиол

1. Charleux, Isabelle. *Nomads on Pilgrimage. Mongols on Wutaishan (China), 1800-1940*. Leiden: Brill, 2015.
2. King, Matthew W. *Ocean of Milk, Ocean of Blood. A Mongolian Monk in the Ruins of the Qing Empire*. New York: Columbia University Press, 2019.
3. Srba, Ondřej. Чин улсын үеийн Монгол оронд хутагт хувилгаад, хүрээ хийдэд мөргөрөө одох заншлыг архивын баримтын үүднээс шинжлэхүй нь. In: *Гадаадын залуу монгол судлаач эрдэмтдийн зуны сургууль* 2011. Улаанбаатар, х. 161-181.

Acknowledgement / Талархал

“Changing Adaptive Strategies of Mobile Pastoralists in Mongolia: Dynamics in Community Histories and Movement Patterns Documented Through Oral Sources” (“Монголын нүүдэлчин малчдын дасан зохицох арга барилын хувирал өөрчлөлт: Нутгийн түүх болон нүүдэл суудлын хэвшил хувиралтыг аман сурвалжаар баримтжуулах нь”, Czech Science Foundation, JUNIOR STAR GM23-07108M) төслийн хүрээнд бэлтгэв.

<https://orcid.org/0000-0002-4777-0905>

УРИАНХАЙГ ЗАХИРАХ ХАЛХЫН МЭЙРЭНИЙ
ЗАНГИ МУНИЖАВЫН ТУХАЙ

КАМИМУРА АКИРА (Япон)

1. Удиртгал

“Баруун Монголын хан, хэргэмтэн, засаг, тайж, түшмэл, ямба олсон лам, суусан газар орныг байцаасан цэс оршив” (2003) доторх “Алтайн урианхайн зүүн гарын сул амбан, мэйрэний занги, үкэри да нарын уг эхийг удаа дараалан орыг нөхөн тавиулсныг тодорхойлон гаргаж өргөсөн өргөдлийн эх данс”-анд,

“Манай Урианхай урьд Тэнгэрийн тэтгэсний 20-р онд дагаар орсон. Дотоод сайд Цэдэн (Чадаг КА) Тэнгэрийн тэтгэсний 32-р онд өвдсөн учирт бие барсан хойно гарсан дотоод сайдын оронд түүний ахмад хөвгүүн Дасхалыг (Тасхал КА) батлан хүргүүлж, Хуувийн сайдуудын газраас айлтгаж, Зарлигаар Дасхалыг сул амбан тавьжээ.

Дасхал Тэнгэрийн тэтгэсний 35-р онд Урианхайг захирах Халхын мэйрэний занги Мунижав лугаа харилцан хэрэлдэж, Дасхал Мунижавыг харааж жанчсан учирт Улиастайн жанжины газраас Дасхал, Мунижав нарыг буруушаан айлтгаж, Зарлигаар Дасхал, Мунижав нарыг тушаалаас байлгаж, түүний гарсан сул амбаны оронд төрсөн дүү Уртнасанг батлан хүргүүлж, Хуувийн сайдуудын газраас айлтгаж, Зарлигаар Уртнасанг сул амбан тавьжээ”

хэмээн гардаг. Тэнгэрийн тэтгэсний 35-р онд Алтайн урианхайн зүүн гарын сул амбан Тасхалтай (Чадагийн хүү) хэрэлдэсэн энэхүү Мунижавын талаар бичсэн зүйл бараг алга байна. Үүнийг тодорхойлбол тухайн үеийн Урианхай болон Халхын харилцаа ямархүү байсныг мэдэж болох юм.

2. Мунижавын тухай хятад, манж эх сурвалжид

Тухайн үеийн Зүүнгар, ойрдын талаарх материал монголоор ховор, харин хятад, манжаар 『高宗純皇帝實錄』 (Тэнгэр тэтгэсэн хааны магад хууль), 『平定準噶爾方略』 (Зүүнгарын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг) зэрэг эх сурвалж байдаг. Энэ хоёр материал дотор гардаг Зүүнгар, ойрдын тухай зүйлүүд нь ихэнх нь давтах боловч Манж Чин улс Зүүнгарын нутгийг эзлэсэн үеийн мэдээ асар их байдаг.

(1) Үүний дотор хамгийн анх гарсан Мунижавын тухай мэдээ нь Тэнгэр тэтгэсний 17-р оны цагаан сарын 22-н буюу хөх бич өдрийн мэдээ болно. Энд “Монгол хошуу захирагч занги Мунижав” гэж гардаг.

Хүснэгт 1

No	1*	2**	Тэнгэр тэтгэсний он	Сар	Өдөр	Өдөр	Он
1	1	1	17	1	22	Хөх бич	1752
2	2	2	17	3	4	Хөхөгчин үхэр	1752
3	3	3	20	9	11	Хар морь	1755
4	4		22	8	12	Цагаагчин хонь	1757
5	5	4	22	10	7	Улаан бар	1757
6	6	5	22	10	7	Улаан бар	1757
7	7	6	23	1	21	Шар бич	1758
8	8	7	23	1	22	Шарагчин тахиа	1758
9	9	8	23	2	19	Хөхөгчин гахай	1758
10	10	9	23	10	6	Шарагчин хонь	1758
11	11	10	23	11	22	Хөхөгчин могой	1758
12	12	11	23	12	23	Хөхөгчин гахай	1758
13		12	24	3	17	Улаагчин тахиа	1759
14	13	13	24	8	7	Хөх бич	1759
15	14	14	24	8	7	Хөх бич	1759
16	15	15	24	8	19	Улаан бич	1759
17	16		24	10	8	Хөхөгчин тахиа	1759
18	17	16	24	12	3	Шарагчин туулай	1760
19	18	17	24	12	10	Улаан нохой	1760
20	19	18	24	12	14	Цагаан бар	1760
21	20	19	24	12	16	Хар луу	1760
22	21	20	24	12	17	Харагчин могой	1760
23	22	21	25	1	20	Улаан бар	1760
24	23	22	25	2	16	Цагаагчин туулай	1760
25	24	23	25	2	21	Улаан бич	1760
26		24	25	3	19	Хөх хулгана	1760
27		25	25	7	20	Хар нохой	1760
28		26	25	7	27	Шарагчин могой	1760
29		27	27	2	21	Хөхөгчин тахиа	1762
30	25		27	5	22	Хөхөгчин туулай	1762
31	26	28	28	1	25	Харагчин хонь	1763
32		29	28	7	19	Хөх нохой	1763
33		30	28	8	1	Хөхөгчин тахиа	1763
34		31	30	3	10	Хөхөгчин тахиа	1765
35		32	32	6	2	Хөх морь	1767
36		33	36	2	9	Цагаан луу	1771
37		34	36	2	9	Цагаан луу	1771

* Зүүгарын газрыг төвшитгэн тогтоосон бодлогын бичиг, **Тэнгэр тэтгэсэн хааны магад хууль

Үүнд: Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин, чин ван Цэнгүнжавын айлтгасан нь: “... Монгол хошуу захирагч занги Мунижавыг урианхайн газарт одуулж, магадлан сурвалжлуулсан газарт, урианхайн газарт худ

урагт учрахаар ирсэн Зүүнгарын хүний хэлэх нь, “Даваач ноднин жил есөн сард тайж Ламдаржаа лугаа муудсан учирт, дуртайяа тайж Даш, Амарсанаа, Банжуур, Цэрэн, Шагдар нар лугаа зөвдөөд их эзэнд дагаж ирсүгэй хэмээсэн бөлгөө. Хойно Даш, Шагдар харин зөвдсөн хэргийг Ламдаржаад хэлсэн учирт, даруй цэрэг аваад нэхээр одож Даваач лугаа байлдваас дарагдаад хойш одов. Даваач бас Амарсанаа, Бамжуур лугаа зөвдөөд хэрэв Дундад улсад дагаж одвоос Алтайн газар цухал, цэрэг байгаад хөндөлдөөс өнгөрөхөд бэрх хэмээн Эрчисээр Хасагийн газарт одов хэмээмүй” гэж байдаг (ЗГТТББ 2020: 772; Хүснэгт 1-гийн No.1).

Мунижав тухайн үед Монгол хошууг захирагч занги (蒙古管旗章京) байгаад Цэнгүнжав түүнийг Урианхайн нутагт явуулаад, Даваач, Амарсанаагийн тухай Чин улсын хувьд чухал мэдээ гаргуулсан юм. Мунижавыг Сайн-ноён хан аймгийн ямар нэг хошууны захирагч занги байсан магадлал өндөр байна.

(2) Дараа нь (Хүснэгт 1-гийн No.2) мөн Тэнгэр тэтгэсний 17-р оны гурван сарын 4-н буюу хөхөгчин үхэр өдрийн мэдээ. Үүнд: Зүүнгарын ард намар цагт хэрэв бас харуулын гадна ирж сууваас, сайд Цэнгүнжав даруй хэрэг ухах, зам мэдэх занги Мунижавыг зарж мэйрэн занги Дондогийн хамт одуулж, уг болзож тогтоосон газрыг барьж буруушаан тодорхойлон ухуулж хэлээд эс суулгаж, хөөн илгээсүгэй хэмээв” (ЗГТТББ 2020: 778). Энд Мунижавыг “хэрэг ухах, зам мэдэх занги” (曉事識路之章京) гэж Урианхайн газрыг сайн мэддэг хүн гэж ойлгодог болсон байна.

(3) Үүний дараа (Хүснэгт 1-гийн No.3) Тэнгэр тэтгэсний 20-р оны 9-р сарын 11-ний өдрийн мэдээнд Амарсанааг оргосны дараа Казахын Аблайд Амарсанаагийн зайсан Гүмжав нартай хамт Мунижавыг илгээсэн (ЗГТТББ 2020: 1057). Түүний тушаалыг “хошууг захирагч зангийн орлогчийн зэрэг” (副管旗章京職銜, мэйрэний зангийн зэрэг) гэж заажээ.

(4) Тэнгэр тэтгэсний 22-р оны 10-р сарын 7-ны өдрийн мэдээ (Хүснэгт 1-гийн No.5) их сонирхолтой. Үүнд: Хамаарсан хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин Цэвдэнжавд тушааж, урианхайн хэргийг шийтгүүлэх тул зарлиг буулгав. Цэргийн тухайн сайд нарт Дээрх зарлиг буулгасан нь: «Цэвдэнжав нарын газраас, бүгдийн дарга Хагт, Алтан нуурт бүхий дөрвөн дэчин урианхайн ардыг дагуулав. Үүнд, Зүүнгарт бүхий үед, хуучин хууль ёсоор өрх тутам өгөх мэдээж булгыг, хожим Оросын ард авсугай хэмээхэд, тэд огт эс өгөв. Одоо дуртайяа дагаж, алба барьсугай хэмээн мэдүүлсэн явдлыг айлтгажээ, Урианхай нар машид хөөрхий. Үүнийг Цэвдэнжавд тушааж тодорхойлон байцааж, дөрвөн дэчиний дарга нар хэрэв цөм дэмч болбаас, даруй сумын занги түшмэл тавьтугай. Хагтад хишиг хүртээж, тогосын отго шагнаж, бас зохихыг үзэж торго шагнатугай. Бас Чадагийн доорх урианхай нарыг угаас алба бариулахгүй бөгөөд шинэ дагаж орсон ардад адилтгаваас нийгэм бус болмуй. Чадагийн доорх урианхай нар урьд Зүүнгарт зургаан булга барьж байсан бөгөөд хожим хоёр хорогдуулж, дөрвөн булга бариулав. Одоо хишиг хүртээн тэднийг гагцхүү хошоод булга бариултугай. Үүнийг цөм Мунижавд тушааж зарлигийг уламжилсугай. Үүнд, бүгд хэдэн өрх буй, бариулваас зохих булга хэд бүхий явдлыг айлгатугай. Бас Чадагийн доорх урианхай

нар цөм алба барихыг дагаж, Чадаг нарт мөн илүү олговоос зохимуй. Үүнийг мөн Мунижавд тушааж байцаан шийтгүүлж, тэдний зэрэгт адилтган дотоод газрын түшмэдээс хагаслан пүнлүү өгтүгэй. Урьд урианхайн хэргийг Цэвдэнжавд тушааж шийтгүүлсэн бөгөөд одоо Цэмцэгжавыг мөн, хамт шийтгүүлтүгэй. Урьд тус тусын нутагт хойш одож, амсхийтүгэй хэмээсэн билээ. Одоо Чадаг нарын цуг урианхай Бохол нарыг шийтгүүлж илгээхийг дагаж, зүй нь одож зүтгэвээс зохимуй. Хэрэг барсан хойно бас хойш нутагт одтугай» хэмээв (ЗГТТББ 2020: 772).

Энд Чин улс урианхайчуудаас үст алба авдаг талаар тодорхой мэдээлсэн байдаг. Зүүнгарт байхад өрх тутам нэг ширхэг булганы арьс өгдөг байснаа өрх тутам хоёрыг өгөхөөр болсон юм. Мөн албыг өгсөн ноёдод дотоод газрын түшмэдийн пүнлүүгийн талыг нь олгодог байсан билээ. Энэ асуудлыг Цэвдэнжав хариуцаж Мунижав ажлыг нь зохион байгуулдаг байсан юм.

(5) Тэнгэр тэтгэсний 23-р оны цагаан сарын 21, 22-ны өдрийн мэдээнд (Хүснэгт 1-гийн No.7, 8) Мунижав урианхай Омбын ардыг барьж олзлоод “урьд урианхайг дагуулахад, үнэхээр зүтгэж явсан бөгөөд эдүгээ Омбын доорх ардыг нэхэж хядахад (хятад орчуулгаар бол (擒剿) “барьж олзлох”, КА) бас шуурхай шийтгэж чадсан нь ихэд сайшаалтай. Үүнд, мэйрэний зангийн пүнлүү шагнан идүүл(эв)” (ЗГТТББ 2020: 1546) гэж гардаг. Мунижав урианхайчуудыг байлдан дагуулахад бас их зүтгэж байсан юм.

(6) Тэнгэр тэтгэсний 23-р оны 12 сарын 23-ны өдрийн мэдээнд (Хүснэгт 1-гийн No.12) ядарсан урианхай өрхийг алба барьж чадахгүй тухайд Тэнгэр тэтгэсэн хаан зарлиг буулгаж “Цэнгүнжавд захиж, тэдний дутсан алба, барих юмыг хишиг хүртээж уучлан хэлтрүүлүгэй. Басхүү Мунижавд тушааж, урианхай нарт ухуул. “Та урьд хэрхэн зовсон билээ? Эдүгээ их эзний албат болсон учирт, жинхэнэ албанаас гадна, огт бусад зовоох зүйл үгүй. Одоо дутсаныг бас уучлан хэлтрүүлэв. Үүнээс хойш, таны бариваас зохих албыг, эрхгүй тооны ёсоор барьтугай. Бас дутуу дулимд хүргэж, хишиг хүртээхийг гуйх санааг суулгаваас болохгүй» хэмээн ухуултугай. Мунижав урианхайн хэргийг шийтгэхэд зүйргүй зүтгэж явав. Түүнд хишиг хүртээж, торго шагна” хэмээв” (ЗГТТББ 2020: 1809) гэж байдаг. Үүнээс Мунижав урианхайчуудтай шууд харилцаж Чин улсын бодлогыг газар дээр хэрэгжүүлж байсан, бас түүний ажлыг эзэн хаан үнэлж байсан нь тодорхой байна.

(7) Мөн Тэнгэр тэтгэсний 24-р оны 3 сарын 17-ны өдрийн мэдээнд (Хүснэгт 1-гийн No.13) “Урьд урианхайг төвшитгөн тогтооход зарлигаар бүх хэргийг Цэвдэнжавыг ерөнхийлөн захирч, Цэмцэгжавыг хамт шийдэхээр тэднийг явуулсан юм. Эдүгээ Цэнгүнжавын айлтгасан газарт, урианхайн албын хэргийн бичгийн дотор Цэмцэгжав, Мунижаваас өөр нэр байхгүй. Цэвдэнжавын нэр алга. ... Харин Мунижав угаас тэдний харьяаны хүн бөгөөд нэг зэргээр хамт хэрэг шийдүүлбээс тохиромжгүй мэт. Иймээс Цэмцэгжавд ганцаараа захирахаар тушаасан. ... Мунижавыг занги байлгаж тэдний шийдснийг дагаж хэрэг шийдүүлж ...” гэж байдаг. Тухайн үед Мунижав бол Цэвдэнжав, Цэмцэгжавын харьяанд байсан боловч Цэмцэгжавтай хамт урианхайн хэргийг шийдэж байсан юм.

(8) Ингээд Мунижав Оорцог обогт хүмүүсийг дагуулан оруулсан юм. Шинээр дагаар орсон тэднийг Чадаг, Түвшинд хавсарган захируулжээ. Тэнгэр тэтгэсний хорин дөрөвдүгээр оны 8 сарын 7-ны өдрийн мэдээнд (Хүснэгт 1-гийн No.14) “Цэнгүнжавын газраас, мэйрэний занги Мунижав нар Цагаан хавын зэрэг газрын Зодов, Бошхон зэрэг тавин долоон өрхийн ардыг дагуулав. Эд цөм оорцог овог, угаас Алтайд нутаглаж үст алба барьж сурсныг дагаж, урианхайн сайд нарт хавсарган захируулсугай хэмээн айлтгажээ. Зодовыг занги, Баяныг орлон хөөгч тавиад, тэдний хорин есөн өрхийг дотоод сайд Чадагт хавсарган захируултугай. Бошхоныг занги, Ярлигийг орлон хөөгч тавиад, тэдний хорин найман өрхийг сул сайд Түвшинд хавсарган захируултугай. Бусдыг цөм тэдний хэлэлцсэн ёсоор болго. Эд хэмээгч цөм шинэ дагуулсан хүн, эрхгүй санаа сүвэгчилж, хураан дарангуйлтугай. Өчүүхэн авч хэрэг дэгдээлгэхэд хүргэвээс болохгүй” (ЗГТТББ 2020: 1975) хэмээн зарлиг буулгав.

(9) Мөн өдрийн мэдээнд (Хүснэгт 1-гийн No.15) Мунижав урианхайн долоон хошуунд шагнал хүртээхийг өргөн барьсан юм. Үүнд: Бас зарлиг буулгасан нь: “Цэнгүнжавын газраас, Мунижавын өргөн барьсан газарт, Чадагийн зэрэг долоон хошууны хүн аливаа албаны хэрэгт үнэхээр хичээж зүтгэж явав. Энэ удаа махчин нарыг нэгжин барихад, хэдий бүрэн барьж олсонгүй авч арав гаруй өрхийн хулгайг хядав, тавь гаруй өрхийг дагуулсны учир, хөхүүлэхийг үзүүлсүгэй хэмээсэн явдлыг айлтгажээ. Үүнд, хишиг хүртээж Чадаг, Түвшин нарт хүн тутам дөрвөөд торго шагна. Мунижав биеийн хүчээр хүнс бэлтгэж, зүтгэн явсныг дагаж нэг зуун лан мөнгө шагна. ... хэмээв (ЗГТТББ 2020: 1975).

(10) Урианхайчуудын Алтай, Эрчист нүүх хүсэлтийг Мунижав дээш дамжуулсан билээ (Хүснэгт 1-гийн No.16). Үүнд: Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин Цэнгүнжавд тушааж, урианхай нарын нутгийг нүүлгэх тул зарлиг буулгав. Цэргийн тухайн сайд нарт Дээрх зарлиг буулгасан нь: “Цэнгүнжавын газраас, Мунижавын хэлсэн Чадаг нар тэдний одоо суусан Ховдын зэрэг газар булга байхгүйд тэднийг Алтайг давж Эрчисийн эх газарт нутаглуулах ажааму хэмээн гуйсан явдлыг уламжлан айлтгажээ. Чадагийг доорх урианхай нар энэ хэдэн жил үнэхээр зүтгэж явсан бөгөөд одоо Эрчисийн газар мөн хоосон үлджээ. Үүнд, даруй тэдний гуйсан ёсоор болговоос мөн болмуй. Гагцхүү Эрчисийн газар угаас дөрвөдийн ардын нутаг бөгөөд, эдүгээ Цэрэн-Убаш нар Улаангомын газарт нутаглан суув. Урьд тэднийг хэрэв дуртайяа уг нутагт суусугай хэмээвээс, тэдний дураар болтугай хэмээн зарлиг буулгасан билээ. Үүнийг Цэнгүнжавд захиж, Цэрэн-Убаш нарт ухуулж хэл. Чадаг нар Эрчисийн зэрэг газарт нутаглуулах ажааму хэмээн гуйсан явдлыг айлтгахад, зарлигаар Эрчисийн газар угаас таны хуучин нутаг, эдүгээ Чадагийн гуйсан газар хэрэв таны нутагт хамаагүй болбаас, даруй Чадаг нарын гуйсан ёсоор болговоос болмуй. Та хэрэв дуртайяа уг газарт хойш одсугай хэмээвээс, одоо хасагийн ард бүрэн дагаж, Илийн хулгай нарыг дуусган хядав. Огт айх зүйлгүй, даруй нүүж суутугай. Таны одоо нутаглаж суусан газрыг, даруй Чадаг нарт шаганаваас болох буюу. Гагцхүү хасагийн ард шинэ дагасан хүн, таны хуучин

дундун ардад адилтгаваас болохгүй. Эрхгүй доорх ардыг чандлан захирч, дуугүй жаргалж суутугай, бүү хэрэг дэгдээлгэх. Хэрэв Хасагийн хязгаарт орж, тэднийг зовоон явбаас тэд айлтгасан хойно би зарлиг буулгахад бэрх болмуй. Та цаазыг сахиж, дуугүй аж төрөхөд, хасагийн ард харин ирж таныг зовоох болбаас, даруй барьж алах, үхүүлэх явдлыг алинаар ч шийтгэвээс цөм болмуй. Та хэрэв сууж идээшсэн, нүүхэд дургүй болбаас даруй хэлэлцэх газаргүй. Энэ Эрчисийн зэрэг газрыг үлдээж хасаг, оросын ардад сэмээр эзлүүлэх байтугай, урианхай нарыг илгээж суулгахад хүрэхгүй. Энэ зарлигийг мөн Чадаг нарт тодорхойлон ухуулж, доорх урианхай нарыг сайхан захирч, жаргаж аж төртүгэй, бүү хэрэг дэгдээлгэ. Басхүү хэрхэн зүй зохисоор хэлэлцээд айлтга” хэмээв (ЗГТТББ 2020: 1979).

(11) Энэ асуудлын талаар Тэнгэр тэтгэсний 24-р оны 10 сарын 8-ны өдрийн мэдээнд (Хүснэгт 1-гийн No.17) “мэйрэний занги Мунижавыг зарж, дөрвөдийн нутагт одож ухуулсанд, чин ван Цэрэн-Убаш нар бүгдээр хэлэх нь, “Чадаг нарын гуйсан нутаг гэгч урианхайн хуучин нутаг. Манай нутгаас ташаалсан бөгөөд эдүгээ Улаангомын газар тариалан өн бөгөөд хонины үржил бас сайн. Энэ газарт сууваас удахгүй манай дөрвөдийн ард даруй хогшмуй. Дуртайяа нүүхгүй, уг хэвээр энд суумуй хэмээн хэлмүй. Сайд бид хянан санаваас, дөрвөдийн ард нутгийг нүүлгэхэд дургүйг дагаж, Чадаг нарын гуйсан ёсоор нутгийг Борж Хяранаас Алтайн өвөрт хүртэл сунгаж, тэдний доорх ардыг хурааж нутаглуулсугай” хэмээн айлтгасанд, Дээрээс явуулав” (ЗГТТББ 2020: 2023-2024) гэж Мунижавыг Дөрвөдийн нутагт явуулсан тухай өгүүлдэг.

(12) Тэнгэр тэтгэсний 24-р оны 12-р сараас хойш нүүсэн урианхайчуудыг казахууд уулгалах болжээ. Тиймээс Мунижавыг явуулж тэрхүү казахууд болон хил хязгаар дахь оросуудын байдлыг удаа дараагаар судлуулсан. (Хүснэгт 1-гийн No.18-29) Мөн Мунижавыг Бээжинд ирүүлжээ (Хүснэгт 1-гийн No.26).

(13) Тэнгэр тэтгэсний 27-р оны 5 сарын 22-ны өдрийн мэдээнд (Хүснэгт 1-гийн No.30) Захчин, Урианхайн аймагт тамга олгохоор болж, Тагна урианхайн тамгыг Мунижавд түр захируулах болжээ.

Үүнд: Захчин, урианхай аймагт тамга цутгуулж өгөх зэрэг явдлыг хэлэлцэв. Хязгаар дахиныг тогтоогч зүүн этгээдийн туслагч жанжин Цэнгүнжав нарын айлтгасан нь: “Одоо Захчины ард нэг хошуу, Алтайн урианхай долоон хошуу, Тагна урианхай дөрвөн хошуу тус тус тариа тарьж, мал адуулж аж төрмүй. Эд цөм харуулын гадна сууж, хэдий тус тусын бүгдийн дарга тавьсан авч угаас тамга эс олсон бөгөөд харуулыг гарч, орж явахад огт тэмдэггүй. Байцааваас, урьд дөрвөдийн хан, ван засаг нар тамга өгмү хэмээн гуйсныг сайд бид айлтгаж, хишиг хүртээн шагнаж илгээсний тул, олдвоос эдэнд нэгэн адил тамга шагнаж өгсүгэй. Тагна урианхай нар басхүү хэргийн хүнд хөнгөнийг ухах хүнгүй, тамгыг түр мэйрэний занги Мунижавт бариулж, харьяат бүгдийн дарга нар тэдний доорх ардыг захирч дарангуйлахыг мэдсэн цагт жич шагнаж өгсүгэй” хэмээн айлтгасанд, Зарлиг: “Цэргийн тухайн сайдууд хэлэлцээд айлтга” хэмээв. Дагалдаагаар хэлэлцсэн нь: “Захчин, Урианхайн ард Тэнгэрийн тэтгэсний арван есдүгээр оноос нааш дараа

дараагаар дагаж орсонд, тэдний өрх ам олон цөөнийг үзэж, хошуу сум зохиов. Захчины хоёр мянга гаруй амыг нэг хошуу, есөн сум, урианхайн дөрвөн мянга дөрвөн зуу гаруй амыг долоон хошуу, хорин таван сум, Тагна урианхайн дөрвөн мянга найман зуу гаруй амыг дөрвөн хошуу, арван зургаан сум зохиож, бүгдийн дарга тавьсан авч тамга эс олгосны тул үүнийг Цэнгүнжавын айлтгасан ёсоор захчины гүн Жамц захчины нэг хошууны бүгдийн даргын тамга нэг, урианхайн дотоод сайд Чадаг нарт Алтай урианхайн долоон хошууны бүгдийн даргын тамга нэг, Тагна урианхайн дөрвөн хошууны бүгдийн даргын тамга нэгийг олгосугай. Тамганд манж, монгол үсэг хавсаргаж цутгуулах явдлыг, Цахарын бүгдийн даргын тамгын ёсоор цутгуулж, ялган салгаж шагнаан өгөхөөс гадна, Тагнын бүгдийн даргын тамгыг мэйрэний занги Мунижавт түр бариулсугай. Жич Алтан нуурын урианхай долоон зуу гаруй амыг дөрвөн сум, хоёр хошуу болгоод, эдүгээ бүгдийн дарга Жарнаг, Балсан захирчээ. Эдэнд тамга олгуулваас зохих, эс зохих явдлыг харьяат жанжны газраас огт дурдаж эс гаргав. Үүнийг Цэнгүнжавт тушааж, тодорхойлон байцаагаад айлтгасугай” хэмээн айлтгасанд, Дээрээс явуулав. (ЗГТТББ 2020: 2329-2330)

(14) Алтай урианхайн тамгын тухай Тэнгэр тэтгэсэн хааны магад хуульд (ТТХМХ 676 боть, Тэнгэр тэтгэсэн 27-р оны 12 сарын 12-ны 1-р зүйл), Цэнгүнжаваас Алтай урианхайг хоёр гар хувааж захирахыг гуйсан бөгөөд зүүн гарын бүгдийн даргын тамгыг Чадагт, баруун гарын бүгдийн даргын тамгыг Түвшинд олгохоор болжээ.

(15) Цэнгүнжавын доор Чадаг, Мунижав ер нь хамтран ажиллаж байсан юм. Тэнгэр тэтгэсний 32-р он (ТТХМХ 786 боть, Тэнгэр тэтгэсэн 32-р оны 6 сарын 2-ын 1-р зүйл; Хүснэгт 1-гийн No.35) Чадаг өвчнөөр нас барчээ. Түүний зүтгэлийг үнэлж зуун лан мөнгөөр шагнаж түүний хүүд бүгдийн даргын зэргийг залгамжлуулжээ. Мөн Цэнгүнжаваар “Урианхайн хэргийг шийдэх” (辦理烏梁海事務之) Мунижаваас Чадагийн оронд тухайн хэргийг шийдүүлбэл зохих хүн хэн байхыг асуулгасан юм.

(16) Тэнгэр тэтгэсний 33-р он Урианахайн сул амбан Түвшин нас барж хүү Исүд залгамжилжээ. (ТТХМХ 824 боть, Тэнгэр тэтгэсэн 33-р оны 12 сарын 15-ны 6-р зүйл)

(17) Тэнгэр тэтгэсний 36-р он “Урианхайн мэйрэний занги” (烏梁海副都統) Мунижав, бүгдийн дарга Танх? (塔恩哈) заргалдаад үүнийг шийдэхээр шадарт явах хиа, дотоод сайд Батжаргалыг явуулсан (ТТХМХ 878 боть, Тэнгэр тэтгэсэн 36-р оны 2 сарын 9-ний 2-р зүйл; Хүснэгт 1-гийн No.36). Энэ нь “Цэс”-т байсан хэрүүл, зодооны зарга байж магадгүй.

Чадагийн ахмад хүүгийн нэр нь Хойдыг хөөж барьсанд шагнал олгосон тухай мэдээ (ТТХМХ 537 боть, Тэнгэр тэтгэсэн 22-р оны 4 сарын 20-ны 3-р зүйл), Ховдод суух жасааны тухай мэдээнд (ТТХМХ 537 боть, Тэнгэр тэтгэсэн 22-р оны 4 сарын 20-ны 3-р зүйл) “Тасхал” (塔斯呼勒) гэж гардаг. Энэ хэргийг жигшиж зориуд буруу нэрийг тавьсан байж магадгүй юм.

(18) Мөн өдрийн мэдээнд “Цэвдэнжав нар айлтгаад урианхайн мэйрэний занги Мунижав нас яваад сул болсон тулд тайж Данжуур, Дэлэгдаш хоёрын аль нэгийг сонгон явуулахыг гуйв. Урьд урианхайн хэргийг өөр хүн явуулж шийдүүлж байсан нь урианхайчуудыг анх дагаар ороод дотоод газрын ёс хуульд нэвтэрхий бус хэмээн айж тусгайлан хүн явуулж захируулж байсан юм. Эдүгээ тэд дагаар ороод удаад тусгай хүн явуулбаас мөн Мунижавын адил дэмий товог учруулах болно. Нэгэнт Улиастай, Ховдод жанжин сайд нар сууж буй учир цаашид Ховдын сайдын захиргаанд шилжүүлж, Улиастайн жанжны мэдэлд хэвээр байлгасугай” гэж байдаг (ТТХМХ 878 боть, Тэнгэр тэтгэсэн 36-р оны 2 сарын 9-ний 3-р зүйл). Үүнээс хойш Алтай урианхайчууд Халхын захирагчгүй болжээ.

3. Мунижавын тухай монгол эх сурвалжид

Тагна урианхайн гарал үүслийг бичсэн “Урианхайн уг язгуур гарал үүслийн товч түүх” (ҮНС134648) гэдэг гар бичмэлийн 4-р нүүрт, “Дараагаар ван Чингүнжав самууран урвахад урианхайгаас цэрэг жагсаасныг урианхайн тэргүүлсэн хүн, зайсан Хоролмойн хувгүүн зайсан Даш дарсан учирт Тэнгэр тэтгэсний хорин дөрөвдүгээр онд учрыг гаргаж уламжлан айлтгасанд Дашид хишиг хүртээж бүгдийн дарга тавьж тогосын отго шагнаан хатгуулжээ. Бас Тэнгэрийн тэтгэсний мөн хорин дөрөвдүгээр онд Хэм голын урианхайн зайсан Эринчин, Тож нуурын урианхайн зайсан Бат, Хөвсгөл нуурын урианхайд төлөвтэй хүн үгүйн тул Халхын Засагт хан аймгийн монгол хүн Эшдэнг эдний хамт цохож, айлтгаад бүгдийн дарга тавьж өөр өөрийн урианхай ардыг захируулж ийнхүү дөрвөн хошуу зохиож хошуу нэг бүр дөрвөн сум байгуулав” гэж байдаг. Халхын Засагт хан аймгийн хүнийг Хөвсгөл нуурын урианхайн хошууны бүгдийн дарга тавьсан болно.

Мөн бичмэлийн 5-р нүүрт, “Бас Тэнгэрийн тэтгэсний хорин долдугаар онд ... урианхай нар бичиг мэдэж хэрэг ухахгүйн дээр шагнасан тамгыг Халхын мэйрэний занги Мунижав, тайж Гүмжав, туслагч Дэлэгдаш нарын гурван түшмэдийг удаа дараагаар суулган захируулжээ” гэжээ. Энэхүү тайж Гүмжавын тухайд Фан (樊 2004: 68) Тэнгэр тэтгэсний 29-р онд Мунижавыг Алтай урианхай руу шилжсэний дараа, оронд нь Жан чин мэнд явах Халхын тэргүүн зэргийн тайж Гүмжавыг явуулж Тагна урианхайн бүгдийн даргын тамгыг бариулсан гэж бичсэн байдаг. Эсвэл бэйл Лувсанцэрэнгийн туслагч тайж Гүмжав байж магадгүй.

4. Чин улсад дагаар орсон урианхайчууд бусад урианхайчуудыг дагаар оруулсан нь

Алтай урианхайчууд Тэнгэр тэтгэсний 19-р он, 20-р оны хооронд Чин улсад мянга мянган өрхөөр дагаар оржээ.

Тэнгэр тэтгэсний 19-р оны 9 сард Бади айлтгасанд: Урианхайн зайсан Чэгэн болон түүний доорх урианхайчуудыг барьж хэдэн түмэн толгой малыг хураасан (ТТХМХ 473 боть, Тэнгэр тэтгэсэн 19-р оны 9 сарын 26-ны 3-р зүйл).

Мөн оны 10 сард мөн Бади айлтгасанд: зайсан Чулууныг, түүний харьяа дөрвөн дэмч өрхтэй хамт барьсан (ТТХМХ 474 боть, Тэнгэр тэтгэсэн 19-р оны 10 сарын 1-ний 7-р зүйл). Мөн 10 сард үүний гавьяагаар Банди, Сааралын зэргийг дэвшүүлж онц шагнасан билээ (ТТХМХ 475 боть, Тэнгэр тэтгэсэн 19-р оны 10 сарын 28-ны 1-р зүйл). Чадагийн хувьд мөн оны 11 сарын 17-ны мэдээнд “шинээр дагаар орсон Чадаг” гэж гардаг учраас түүнээс өмнө 7-р сараас 10 сарын хооронд дагаар орсон байж магадгүй (ТТХМХ 477 боть, Тэнгэр тэтгэсэн 19-р оны 11 сарын 17-ны 2-р зүйл).

Мөн Тэнгэр тэтгэсний 19-р оны 11-р сарын 22-ны өдөр шинээр дагаар орсон урианхайчуудыг хошуу байгуулж сум сумаар хуваажээ. Зайсан Чэгэн, Чулууныг гуравдугаар зэргийн бүгдийн дарга (三品總管), мэйрэн зангийн зэрэг Чадагийг бүгдийн дарга тавьжээ (ТТХМХ 475 боть, ТТ 19-р оны 10 сарын 28-ны 1-р зүйл). Мөн Тэнгэр тэтгэсний 20-р оны цагаан сарын 10-ны мэдээнд, Чадагийг Буучин нарыг дагаар оруулснаар мэйрэн занги тавьжээ.

Тэнгэр тэтгэсний 20-р оны 2-р сарын 11-ний өдөр Чадагийн харьяаны 46 өрхөөр нэг сум зохион Хөвөөт шар хошуу, Доточийн Эгшиг зэрэг 18 өрхийг оруулж Чулууны харьяаны 205 өрхөөр гурван сум зохион Шулуун шар хошуу, Чэгэнгийн харьяаны 67 өрхөөр нэг сум зохион Шулуун цагаан хошуу, Ярдын харьяаны 135 өрхөөр хоёр сум зохион Хөвөөт шар хошуунд багтаажээ (ТТХМХ 482 боть, ТТ 20-р оны 2 сарын 1-ны 3-р зүйл).

Мөн Тэнгэр тэтгэсний 20-р оны 5-р сарын 8-ны өдөр Чадагийн харьяа байсан Урианхайн зайсан Түвшин зэрэг 200 гаруй өрх дагаар оржээ. Халхын бэйл Цэвдэн, Чадаг нарын цэрэг хүрмэгц бууж өгснөөр Түвшинг Уринахайн 3-р зэргийн бүгдийн дарга (烏梁海三等總管) тавьжээ (ТТХМХ 488 боть, ТТ 20-р оны 5 сарын 8-ны 4-р зүйл). Дараа жил Тэнгэр тэтгэсний 21-р онд Түвшинг сул амбан (ТТХМХ 509 боть, ТТ 21-р оны 3 сарын 23-ны 1-р зүйл), Чадагийг мөн оны 9 сард дотоод сайд (ТТХМХ 509 боть, ТТ 21-р оны 9 сарын 11-ний 6-р зүйл) тавьжээ.

Ингээд Чин улсад шинээр дагаар орсон урианхайн зайсан нар эргээд бусад урианхайчуудыг дагаар оруулаад ноёдын зэрэг нь дэвшсэн юм. Чадаг дотоод сайд (дэд 1-р зэрэг) байхад Мунижав мэйрэний занги (жинхэн 2-р зэрэг) байжээ.

5. Дүгнэлт

Мунижав Монгол хошууг захирах занги байгаад урианхайн нутагт очиж газар дээр нь урианхайчуудтай шууд харилцаж Банди-Сааралын үеэс эхлээд Цэнгүнжав-Цэвдэнжав болон Цэмцэгжавын үе хүртэл Чин улсын бодлогыг урианхайчуудад хэрэгжүүлж байсан. Тэрвээр тагнан судлах, хэлэлцэх, үст алба татварыг зохицуулах, байлдан дагуулах зэрэг бүх талаар Чин улсын төлөө зүтгэж явсан хүн билээ.

Түүнийг Тэнгэр тэтгэсэн хаан ч гэсэн үнэлэн сайшааж урианхай, казах, орос гэх мэт баруун хойд хязгаарын ардуудын байдлын талаар байнга асуудаг байжээ.

Мунижав Чин улсын захиргааны системийг нэвтэрхий мэддэг, урианхайг дагнан судалсан хүний хувьд Чадаг мэт урианхайн ноёдыг цэргийн гавьяа байгуулан тушаал зэргээ дэвшүүлж Чин улсын захиргаанд боломжийн байр суурь эзэлж явахад түүний хэрэгцээ нь буурч Чадагийн хүү Тасхалтай хэрэлдсэнээр байр тушаалаас огцруулахад хүрчээ.

Мунижав бол Халхын талаас урианхайчуудыг захиран дарангуйлах тогтолцоог бэлэгдэх анхны болон сүүлийн хүн байсан юм.

Ном зүй


1. Дашням, Г., Гантулга, Ц., Сүхбаатар, На. (хэвлэлд бэлтгэсэн). 2003. Баруун Монголын хан, хэргэмтэн, засаг, тайж, түшмэд, ямба олсон лам, суусан газар орныг байцаасан цэс орошив. УБ. (Цэс)
2. ТТХМХ『高宗純皇帝實錄』(Тэнгэр тэтгэсэн хааны магад хууль), <https://sillok.history.go.kr/mc/inspectionMonthList.do>
3. ЗГТТББ. Сүхбаатар, На.(эрхэлсэн), Түвшинтөгс, Б., Оюунжаргал, О. (ред.). 2020. Зүүнгарын газрыг төвшитгөн тогтоосон бодлогын бичиг. УБ.
4. 樊明方. 1992.「清朝对唐努乌梁海地区的管辖」『中国边疆史地研究』1996年第2期: 42-59.
5. 樊明方. 2004.『唐努乌梁海历史研究』中国社会科学出版社.

АЛТАЙН УРИАНХАЙН БАРУУН ГАРЫН ЧҮЛТЭМ ДА ЛАМЫН НАМТАР (1886-1939)

Оръяс Мөнгөнхүүгийн ГАНБОЛД

Соёлын Өвийн Үндэсний Төв, профессор, Түүхийн ухааны доктор (Ph.D)

Чүлтэм нь 1886 онд Ховдын хязгаарын Алтайн урианхайн 7 хошууны Баруун гарын Баруун амбаны хошууны ноён, тайж Хар Гилэнгийн хүү Самбуугийн гурав дахь хүү болон Алтайн арын Чингэл голд эхээс мэндэлжээ.



Алтайн урианхайг захирагч Баруун гарын бүгдийн даргын тамга
1763 онд Манж чин улсын засгаас Алтайн урианхайн сул амбан Төвшинд олгосон
“Алтайн урианхайг захирагч Баруун гарын Бүгдийн даргын тамга”.
(Монгол улс, Улаанбаатар хот, Богд хааны ордон музей. Дугаар 24-8-92).

Бага насандаа Баруун амбаны Дашчойнхорлон хэмээх их хүрээнд шавилан сууж, шарын шашны ном эрдэмд нэвтэрхий суралцсан байна. Аман түүхийн мэдээгээр 25 орчим насандаа тус хүрээний Да ламаар өргөмжлөгдсөн бололтой байдаг. Да лам гэдэг нь шашны хурлын захиргааны хэрэг эрхэлсэн албан тушаалтны хэргэм зэргийн хэлнэ. Баруун амбаны Их хүрээний шашин болон захиргааг хариуцсан дээд лам юм.